

ЧИНГИС ХААН ТЭНГЭРТ ХАЛЬСАН ГАЗРЫН БАЙРШЛЫГ ТОДОРХОЙЛОХ ОРОЛДЛОГО

Ш.Баатар АНУ-ын Станфордын их сургууль

Өгүүллийн товч утга: Их Монгол улсын хаяаг тэлж, дайснаа төвшитгөх урд удаан хугацааны их аян дайнд мордож яваад Чингис хаан тэнгэрт хальсан газрын байршлыг тогтоох сонирхол судлаачдын анхаарлын төвд байсаар иржээ. Чингис хаан Тангуд улсыг (Баруун Ся, Гашин улс, Xi Xia) байлдан дагуулж яваад тэнгэрт хальсан түүхэн үйл явдалтай эрдэмтэд санал нэг байдаг. Тангуд орны чухам ямар газарт Чингис хаан өөд болсон талаар судар бичигт зөрөөтэй олон баримт бий. Дэлхий даяарчлагдаж, харилцаа холбоо хөгжих тутам Чингис хааны тэнгэрт хальсан газрын байршлыг тогтоох судалгаа явуулахад улам дөхөмтэй болжээ. 2005 онд түүхч Ц.Батбаяр Хятад улсын Нинся мужид "Чингис хааны амьдралын сүүлчийн жилүүдийн ул мөрийг мөшгөх" аялал хийж, сонирхолтой илтгэл тавьсан юм [1]. Тус аялалаас санаа авч, Чингис хааны тэнгэрт хальсан газрын байршлыг тогтоох нарийвчилсан судалгааг Станфордын их сургуулийн номын сан, интернэтийн мэдээлэл ашиглаж хийлээ. Чингис хааны тэнгэрт хальсан газарт монголчуудын байгуулсан тахилгын онгон бий эсэхийг олж тогтоох судалгааны үр дүнд "Хятад улсын Нинся (Ningxia) мужийн Чинтунся (Qingtongxia) тосгоны ойролцоо, Шар мөрний (Хатан гол, Хар Мөрөн, Хуанхэ) эх орчимд Алаша уулын (Хулан уул) зүүн урд хормой дахь Жиакоу толгодын энгэрт байгаа Монголын Юань гүрний үед босгосон 108 суваргатай тахилын сүмийг Чингис хааны тэнгэрт хальсан газар байж болно" гэсэн таамаглал дэвшүүлж байна.

Түлхүүр үг: Их Монгол, Чингис хаан, Тангуд, аян дайн, Баруун Ся, Нинся муж, газрын байршил, Алаша уул, Жиакоу, 108 суваргатай тахилын сүм

1. Чингис хааны сүүлчийн аян дайнд хамрагдсан газар зүйн байрлал

Чингис хаан Хорезмыг эрхэндээ оруулсны дараа нэг жил эх нутагтаа эр цэрэг, хүлэг морьдоо амрааж, өргөсөн тангаргаасаа няцсан Тангуд улсыг мөхөөхөөр хөхөгчин тахиа (1225) жил дайлаар морджээ. Тангуд улсын нутаг дэвсгэрт тус байлдааны үйл ажиллагаа явагдсан учир тухайн орон нутгийн уул усны газар зүйн байршлыг урьдчилан тайлбарлах шаардлагатай юм. Түүхийн сурвалж бичигт Торгоны замыг хянаж ирсэн тангадуудыг төвд (тоба) угсааны хагас нүүдэлчид хэмээн тэмдэглэсэн бол "Монголын Нууц Товчоо"-нд үүнийг баталсан мэт "тэрмэн гэртэй, тэмээн хөсөгтэй", "шавар гэрт шавалдан суудаг" гэж тодорхойлсон байна. Их Монгол улсыг байгуулах цагт Тангуд улс хойд талаараа Найманы ханлигтай, урд талаараа Хойд Сүн улс (Зүрчидийн Алтан улсын хараат), зүүн талаараа Кидан улс (Ляо улс, мөн Зүрчидийн Алтан улсын хараат), баруун талаараа Хар Кидан улс (Баруун Ляо улс), баруун урдуураа Хөхнүүрын Төвдтэй хиллэж, түмэн газрын цагаан хэрмийн баруун үзүүр, Шар мөрний эхээр хүн амаа төвлөрүүлэн хот тосгодоо байгуулж, Хойд Сүн улс, Зүрчидийн Алтан улстай газар нутгаа булаалдан тэмцэлдэж байжээ. Тангуд улсын уугуул нутаг нь одоогийн Хятад улсын Гансу муж, Нинся муж, Өвөр Монголын өөртөө засах орны баруун хязгаар нутгийг хамаарч байжээ. 1958 онд Гансу муж, Өвөр Монголын өөртөө засах орны дунд хэсгийг таслан авч, лалын шашинтай хотон (хуй) үндэстэнд зориулж Нинся мужийг байгуулан, Инчуан (Inchuan) хотыг нийслэл болгосон. Нинся муж одоо 5.6 сая хүн амтай, Тангуд улсын хуучин нийслэл Инчуан нь 800 мянган хүнтэй, Хятаддаа багавтарт тооцогдох хот юм. Сурвалж бичигт тэмдэглэснээр Инчуан хотын эртний хятад нэр Зоншинфу (Zhongxing-fu), тангад нэр Яргай хот, монгол нэр Давст тахир болно. Инчуан хот Нинся мужийнхаа хойд хэсэгт Алаша уулын баруун хормойд оршино. Алаша уулыг хятадаар Хэланьшань гэж нэрлэх ба Хэлань нь хулан гэсэн монгол үгийн хятадчлагдсан дуудлага ажээ.

Алаша уул нь их говийн дунд орших Тэнгэр элс, Ордосын говийн хооронд хойноосоо урагшаа сунаж тогтсон урт нуруу юм. Алаша уулын зүүн хөндийд дэх олон нуурын хотгорт Инчуан хот байрлах байх ба хотын зүүн талаар монголчуудын дунд Хатан гол нэрээр алдаршсан Шар мөрөн урсана [Зураг 1]. Инчуан хотоос эгц урагшаа 20 гаруй километрийн зайнд Шар мөрнийхөө зүүн эрэгт ойрхон газар Монголын түүхэнд Түрэмгий балгас (Линжоу, Lingzhou) гэж тэмдэглэгдсэн Линвү (Lingwu) хот байна [Зураг 2]. Линжоу хотын хуучин нэрийг Хятадын эрдэмтэд олон сурвалжаас нягтлан үзэж, баттай тогтоожээ. Монгол цэргүүд Түрэмгий балгасыг дайлахдаа Есөн олом гэдэг газраар Шар мөрнийг гаталжээ. Нинся мужийн Инчуан нийслэлээс баруун урагш 76 км зайтай Чинтунься (Qingtongxia) хотын ойролцоо Шар мөрний эхэнд буй хавцлын үзүүрт 108 суваргатай Жиакую толгод байна [Зураг 3]. Зуны халуунаас дайжиж, Чингис хааны гарч зуссан Люпаньшань (Liupanshan, Харууна уул) уул Шар мөрний урд зүгт их холгүй байна. Гансу, Нинся, Шаанси гурван мужийг хөндлөн гарсан Люпаньшань уул нь 100 гаруй км урт, байгалийн өвөрмөц тогтоцтой, үзэсгэлэн төгөлдөр, араатан жигүүртнээр баялаг нуруу ажээ. Энэ нурууны зүүн өвөрт торгон замын эх болох эртний Хан улсын алдарт нийслэл Шиан (Шаанси мужийн төв) байна. Зарим сурвалжид Чингис хааныг оршуулсан газар гэж гардаг Мони уул Ордосын говийн ар хэсэгт, Инчуан хотоос зүүн хойш хол газар бий.

2. Тангуд улсыг төвшитгөсөн дайны явц

Тангуд улсын хаан Ли Цзун-ши (Zunzhong) харагчин хонин (1223) жил нас барж, түүний хүү Ли Дэван (De-wang) хаан ширээг залган авч, түшмэл Аша Хамбутай нийлж, Алтан улстай холбоо тогтоон, Эзэн голын сав орчмын Монголын эзэмшил нутагт халдаж эхэлсэн тул Алтан улсыг дайлж яваад харагчин хонин (1223) жил өөд болсон Мухалай жанжины хүү Бор жанжин цэргээ авч, хөх мичин (1224) жил Тангад улсын зүүн талын хот Инчжоу (Yinzhou) руу довтолж, Тангадын жанжин Тахай (Ta-hai) Хамбутай байлдаж ялаад түүнийг амьдаар нь олзолсон гэж Тангад улсын түүхэнд тэмдэглэгдэн үлджээ [3]. Чингис хаан Хорезмыг төвшитгөсний дараа хөхөгчин тахиа (1225) жил 100,000 орчим их цэргээ хоёр хуваан, баруун жигүүрээ Онги орчмоос хөдөлгөн их говийн баруун талаар туулж, Шачжоу хотод (Shazhou, одоо Гансу мужийн Дуньхуан) довтолсон байна. Тангад улсын түүхэнд тэмдэглэснээр Чингис хаан 180,000 цэргээр довтолсон байна. Энэ баримтаас харахад Алтан улсад байлдаж явсан Бор жанжины удирдсан цэрэг Монголын их цэрэгтэй нийлсэн тоо байж болох талтай. Онгиос хөдөлсөн их цэргийн баруун жигүүр Алтайн нурууны зүүн үзүүрийн Арц Богд уулын зүүн хормойг хэдэрч, Тайлгын нурууны баруун шилээр даван Нэмэгт уулын бэлээр гарч, Шинэ усны говийг туулан Гансуд нэвтэрсэн болов уу. Баруун жигүүрийн цэрэг Шачжоу хотыг бүслээд хагас жил суусан байна. Шачжоу хотыг хамгаалагчид удаан тэмцэж, хэдийгээр монгол цэргүүд газар доогуур суваг ухаж хотод орсон ч, өөдөөс нь галаар хуйхалж, тодорхой амжилт олсонгүй. Зарим сурвалж бичигт Шачжоу хотыг хамгаалагчид сөрөг давшилтанд орж Монголын цэргийг бүсэлж, хүнд байдалд оруулж байсан талаар дурджээ. Чингис хааны удирдсан их цэргийн зүүн жигүүр эгц урагш давшиж, Хар хотын (Heisu) чиглэлд довтолжээ. Зүүн жигүүрийн цэрэг хөхөгчин тахиа (1225) жилийн хүйтэн өвөл Цоорхойд (Цоорха) өвөлжөөд, улаан нохой (1226) жилийн 3 сард Чингис хаан Шар Уйгарын цоохор цэргээр Хар хотыг эзлэж, Алаша уул руу давшин, Аша хамбыг барьж аваад, баруун жигүүрийн цэргийг тэндээ хүлээсэн байна. Баруун жигүүрийн их цэргийг удирдаж байсан Худугтөмөр, Тангадаас дагаар орсон жанжин Ли Чуанбу (Quanbu) нар Шачжоу хотыг хамгаалагчдын худал найрсаг хандсан арга мэхнээс зайлан, бүслэлтээс ухран гарч чаджээ. Энэ хотыг Чингис хаан хожим нөхөж эзэлсэн юм.

Баруун жигүүрийн цэрэг Шачжоу хотоос хөдөлж, монголчуудын дунд өссөн Цагаан нэрт тангуд баатар эрийг ашиглан Сучжоу (Suzhou) хотод довтолж. Суджоу хотыг хамгаалагчид өөрсдийнхөө дунд байсан Ли Чуанбу жанжины ахыг алсан тул тус хотыг баруун жигүүрийн цэрэг эзэлж авсны дараа Ли Чуанбу жанжины ах дүүс 106 өрхийг амьд үлдээж, бүх хүнийг хүйс тэмтэрсэн гэж сурвалж бичигт тэмдэглэжээ. Баруун жигүүрийн цэрэг цааш давшиж, Ганчжоу (Ganzhou, Гансу мужийн Зангиз) хотод довтолжээ. Ганчжоу хотын хамгаалагчдын дотор Цагаан баатарын аав байсан учир хэрмэн дээгүүр бууж өгөхийг шаардсан бичиг Цагаанаар харвуулсан боловч хотыг хамгаалагч Ачу түшмэл бусад 36 түшмэлтэйгээ зөвлөлдөж, Цагаан баатрын эцэг дүү нарыг алаад эсэргүүцэн байлджээ. Баруун жигүүрийн цэрэг хотыг эзлэхээр 6 удаа довтолоод дийлээгүй тул Чингис хаан зүүн жигүүрийн цэргээ Ганчжоу хотод татаж, хүч нэмэн тулалдаад хотыг эзлэн авч, бүх хүнийг алах гэсэн боловч Цагаан баатрын хүсэлтээр тэдний амийг хэлтрүүлжээ. Монголын их цэрэг улаан нохой (1226) жилийн 8 сард Шилианьфуд (Xiliang-fu) довтолж, хотыг бүслэн буулган авснаар Тангудын баруун тал бүтнээрээ монголчуудын гарт оров. IX сард Ли Чуанбу жанжин Заньбин (Zhang-bing) хотыг эзэлж, Чингис хаан Шар мөрнийг Есөн олмоор гатлан Тэнгэр элсийг давж, Иньли хотыг эзэлж авсан байна. 11 сард Шилианьфу хотыг бүслэх үед баруун, зүүн жигүүрийн цэрэг хоорондоо бүрэн нийлжээ. Энэ үед Яргай хотыг сахиж байсан Вэйминьлинь-гон жанжин 100,000 цэргээ хотоос гаргаж, Алаша ууланд монголчуудтай байлдахаар уриалан дуудахад Монголын цэрэг Хатан голыг мөсөөр туулж, Алаша ууланд бүгсэн Тангадын цэргийг бут цохисон байна. Вэйминьлинь-гон жанжин үлдсэн цэргээ Тангудын хан хүү Дэ-рэнгийн хамт авч зугтан Түрэмгий балгасанд (Линчжоу) шурган оржээ. Чингис хааны их цэрэг 11 сард Түрэмгий балгасыг эзлэн авч хан хүү Дэ-рэнг алжээ. Чингис хаан тангадууд Алтан улсаас тусламж ирэх замыг хааж Яньчжоуд байрлан, цэрэг агтаа амраагаад өвөл нь Яргай хотыг бүслэж, бага хэмжээний цэрэг суулган, их цэргээ авч Шар мөрнийг мөсөөр гаталж, мөрний зүүн хязгаарын жижиг хотуудыг эзлэв. Чингис хаан Хөхнуур орчмыг эзлээд, улаагчин гахай (1227) жилийн II сард Лантао, III сард Тучжоу, Хэйчжоу, Сининчжоу хотуудыг эзлэн аваад 4-р сард Люпаньшань ууланд зуны халууныг өнгөрөөхөөр иржээ. Мухулайн үхлээс хойш зогсонги байдалд орсон Алтан улсад довтолж байлдааны ажиллагааг Чингис хаан тэндээс эрчимжүүлж, Люпаньшань уулын хормой дахь Алтан улсын жижиг хотуудыг толгой дараалан эзэлсээр байлаа. Энэ хугацаандаа Цагааныг Тангадын Бурхан хаанд элчээр илгээжээ. Нас барсан Ли Дэван хааныг залган авсан Ли Сян (Бурхан хаан) бэлэг сэлтээ хэдэн сар бэлтгэж, өөрийн биеэр Чингис хаанд бараалхахаар ирсэн боловч, хааны бие чилээрхсэн тул Хонхтоны Толун чэрбиэр угтуулж, Бурхан хаанд Шударга нэр өгөөд түүнийг Толунаар цаазлуулжээ [2,3,8,9]. Чингис хаан 8-р сарын 18-нд Люпаньшань уулын баруун өмнө Цунь шуй цянь-д нас барсан нь бодит үнэний хувьтай гэж түүхч Ч.Далай "Их Монгол улс" номондоо бичжээ [5]. Хэрвээ миний судалгаанд дурдагдаж байгаа 108 суварга барьсан толгодын ойролцоо Чингис хаан тэнгэрт хальсан байж болох таамаглалыг бодитой гэж үзвэл энэ газар нь Люпаньшань уулын ар, Түмэн газрын цагаан хэрмийн дотор талд, Хатан голын эхэнд орших хавцлын үзүүрийн Жиакоу нэртэй газар болно. "Эрдэнийн товч", "Алтан товч", "Шинэ Юань ши" зэрэг сурвалжид бичсэн "Түрэмгий балгасанд (Линчжоу) нас барав", бусад эх сурвалжид бичсэн "Люпаньшань уулын Цинь шуй сянд нас барсан" гэсэн хоёр газрын яг дундын зайнд Жиакоу байна. "Сүн ши" (Сүн улсын түүх), "Юань ши син бянь" (Юань улсын түүхийн шинэ эмхтгэл) сурвалжуудад [5] дурдсан Люпаньшань уулнаас 108 суваргатай тахилгын газар их холгүй оршино. Чингис хааны үхлийн гол шалтгаан нь Арбухад хулан агнаж яваад мориноос унаж хүнд бэртээд жилийн дотор нас барсан гэж ихэнх судар бичигт

дурьддаг. Өвөр Монголын эрдэмтэн На.Батжаргал Арбухыг Ордосын Хатан голын тахирласан тохой дотор орших Арбух уул гэж тодорхойлсон [5] ба энэ газар ч Чингис хааны нас барсан гэж өмнө дурдсан газруудад мөн ойрхон байна.

3. Юань гүрний үеэс уламжлагдан үлдсэн суварганы соёл

Саган Цэцэний дурдсанаар Хубилай хаан 50 настайдаа хөх хулгана (1264) жилээс цагагчин хонин (1271) жилийн хооронд 8 жилийн турш зуны ордон Шандад Кэйбүн Хүрдү Балгас, өвлийн ордон Их Дайду Хот, Алтай Арлын сүүдэр талд Цагаан Балгас, Эрчүгинд Ланьгинь Балгас хэмээх дөрвөн их хотыг байгуулжээ [10]. Хожим XIX зууны дунд үед монголчууд Шандын Хүрдү Балгасын туурийг "108 сүмийн хот" гэж нэрлэж байжээ [10]. Энэ бол Шандын Хүрдү Балгасанд 108 сүм хийд байсан, монголчууд 108 хэмээх тоог эртнээс эрхэмлэдгийн нэгэн баримт юм. Фрэнсис Клийвз (Francis Woodman Cleaves) Хар Хоромын Эрдэнэ зуугаас олдсон улаан нохой (1346) жил хөшөөний бичээсийн судалгааг хийж, Мөнх хаан (Сяньзун) улаан луу (1256) жил 5 давхар асартай, 90 метр өндөр суварга барьсан тухай уншиж тогтоосон байна [19]. 5 давхар асарт суварга олон жилийн дайн тулааны хөлд үрэгдэж алга болжээ. Юань улсын үеийн дурсгал болох олон давхар асартай хэд хэдэн суварга Нинся, Гансу мужид уламжлагдан үлдсэн байна. Юань гүрний үед Монгол оронд бурханы шашины Сажагийн ёс дэлгэрч сүм хийд, суварга олноор бүтээж байснаас нэлээд нь Хятад оронд өнөөг хүртэл ийнхүү уламжлагдан үлдсэн байна. Дайду (Бээжин) дахь их цагаан суварга [Зураг. 4], Чингис хаантай уулзахаар морилж яваад зам зуураа Ланчжоуд өвчнөөр таалал төгссөн Саржа ёсны тэргүүн ламд зориулан босгосон Гансу мужийн 17 метр өндөр цагаан суварга [14], Нинся мужийн Жиакоу толгодын 108 суварга [Зураг. 5], Хубэй мужийн цагаан суварга нь Балбын алдарт Анигэ (Anige) дарханы Бурхан багшийн чандарыг хадгалагч болор сүмбэр" мэтийг бэлэгдсэн загвараар бүтсэн, хаанаас нь ч хэн ч харсан Юань улсын үеийн дурсгал гэж хэлэхүйц өвөрмөц онцлогтой юм.

Дайду дахь их цагаан суваргын дурсгалын хөшөөнд "Улаан хулгана (1096) жил Ляо (Китан) улсын босгосон суварганы дотор хадаглаж байсан Бурхан багшийн шарилын үлдэгдэл бүхий эрдэнэсийн хайрцгийг гарган авч, Хубилай хааны зарлигаар хуучин суваргыг нураан, суурин дээр нь цагагчин хонин (1271) жил 43 алд (50.9м) өндөр, 7 алд өргөн цагаан суваргыг босгож, эрдэнэсийн хайрцгийн хамт суварганд орох шүншгийг Пагва ламын дүү, Хубилай хааны их багш Ринчинжалцан үйлджээ" гэж бичсэн байна [11]. Шарагчин туулай (1279) жил их цагаан суварганы хажууд Хубилай хааны зарлигаар Их сахиусны түмэн амгалант сүмийг барьжээ [12]. 1368 онд Тогоонтөмөр хааныг Дайдугаас зугтан гарахад тус сүм галд өртөж цагаан суварга л үлджээ. улаагчин могой (1457) жил Мин улсын хаан сүмийг дахин бариулж, Миао-ен (Miaoying) гэж нэрлэсэн байна. Ишбалжирийн "Бурханы шашины түүх" номонд Бээжингийн цагаан суварган дотор Хубилай цэцэн хааны эцэг, эхийн шарил бий гэж дурджээ [13].

4. Нинся мужийн Жиакоу толгодын 108 суварга

Шар мөрний эх бэлчир Алаша уулын хормой талд, 6 км орчим урт хавцалын үзүүр орчмын Жиакоу нэртэй бэсрэг толгодын нэг энгэрт орой дээрээ жижиг тахилын сүмтэй, пирамид хэлбэрээр барьсан 108 суварга байна. Нийт 12 эгнээний хамгийн дээд талдаа нэг, 2, 3-р эгнээндээ гурав гурав, 4,5-эр эгнээндээ тав тав, 6-12-р эгнээндээ 11,13,15,17,19 гэсэн сондгой тоотой суваргатай. Хамгийн дээд талын 3.5 м суваргыг өндөрт байрлуулсан, бусад 2.5 м өндөр 107 суваргыг толгодын бэл дагуулан пирамид хэлбэрээр шатлан бүтээжээ [Зураг.6]. Эгнээ бүрийн завсраар хүн явж гороо хийх боломжтой [Зураг.7]. Энэ 108 суваргын хийц Бээжингийн их цагаан суваргатай тун адил, Юань улсын үед хийгдсэн гэж хятад

шинжээчид үзэж ирсэн. Ном судраас энэ талаар хайж үзэхэд **"зарлиг увьдсын суварга"** хэмээн алдаршсан суваргатай төстэй байна. Онцлог нь суваргын орой дээрх хурын бүрхүүлийг хүрлээр хийсэн, ихэнх тохиолдолд тааралдах наран, саран бэлэгдлийн оронд хоёр давхар бөмбөлөг хийсэн байна. Тус хоёр бөмбөлгийг зарлиг увьдсын суварганд хоёр давхар дэлбээлж буй бадам цэцгээр дүрсэлсэн байдаг. Зарим суваргын хоёр давхар бөмбөлөгт бадам цэцэг дүрсэлсэн харагдана. Хурын бүрхүүл найман талтай байгаа нь дөрвөн зүг, найман зовхис гэсэн Бурханы шашины зүг чигийн бэлэгдлийн утгыг агуулсан байж болно. Зарлиг увьдсын суварга далдлагдсан нууц чанарыг агуулдаг учир хамаагүй тайлбарлаж болдоггүй гэсэн номлолтой ажээ.

Эртний энэ цогцолборыг 1987 онд Хятад улс түүх дурсгалын үнэт зүйлийг сэргээх төслийн дагуу улсын хөрөнгөөр засварлажээ. Нинся мужийн болон Хятад улсын аялал жуулчлалын танилцуулганд 108 суваргын талаар мэдээлэл бараг ороогүй боловч цөөхөн номонд "Юань улсын үеийн дурсгал", "Мин улсын сурвалж бичигт гү та буюу эртний суварга гэж тэмдэглэгдсэн", "хэн ямар зорилгоор барьсан нь тодорхой бус" гэж бичжээ. Саяхнаас Америк, Германы жуулчдын гарын авлаганд 108 суварганы талаар зурагтай мэдээллийг товч оруулж эхэлсэн байна [14]. Нинсяд очиж буй жуулчдад Чинтунся хотын ойролцоо 108 суварга байдгийг нутгийн хүмүүс зааж өгдөг, ихэнх жуулчин Инчуан хотоос автобусаар очиж, энэ гайхамшигт үздэг байна. Ихэнх жуулчид Тангудын хаадын бунханыг үзэх Инчуан хотод ирдэг ажээ.

х

х

х

Юань улсын үеийн дурсгалууд дотор цагаан суварга чухал байр эзэлнэ. Нэгэн цаг үед байгуулагдсан суваргууд учир хоорондоо хэлбэр дүрсээрээ нэн төстэй, нэгнийх нь хийцээр нөгөөг тодорхойлж болох давуу талтай. Тухайлбал, Бээжингийн их цагаан суваргын тайлбар дурсгалын хөшөөний хуулж үлдээсэн бичигт тодорхой мэдээлэл байна. Юань улсын Хубилай цэцэн хаан дөрвөн том хотоо барих цагт Бурханы шашиныг дэлгэрүүлэх үйлстэй уялдан цагаан суварга босгох ажил өргөн хүрээтэй явагдаж байжээ. Хубилай хаан нь Чингис хааны ач хүү учир их хаан тэнгэрт хальсан газар орныг маш сайн мэдэж байсан нь мэдээжийн хэрэг юм. Тийм болохсёр Хубилай хааныг Аригбөхтэй хаан ширээ булаалдан тэмцэлдэж байхдаа Чингис хааны шарилыг Бээжингийн Бэйхай (хойд нуур) цэцэрлэгийн ууланд шилжүүлсэн хэмээх домог яриа хятадуудын дунд одоогоор байна. Үүнийг би ор үндэсгүй гэж бодож байгаа боловч Хубилай хаан Дали улсыг өөрийн биеэр дайлсны дараа 1254 онд Люпаньшань ууланд зуссан, номын багш Пагва ламтайгаа энэ ууланд анх уулзсан тухай хятадын сурвалжид олонтоо тэмдэглэгджээ [1]. Хубилай хаан Люпаньшань ууланд зуссан гол шалтгаан бол өвөг эцэг Чингис хаан тэнгэрт хальсан газрыг мэддэг, дурсан санадаг байсантай холбоотой болов уу. Номын багштайгаа тэнд уулзаж, Бурханы номыг Монгол газар дэлгэрүүлэх айлдварыг сонсож, Гансу мужийн Ланчжоу хотын ойролцоо ууланд цагаан суварга босгож байсан баримт бий. Энэхүү Чунтонся хотын дэргэд, Хатан голын (Шар мөрөн) хөвөөнд Люпаньшань уулнаас хол биш газар 108 суваргыг Чингис хааны тэнгэрт хальсан газар Хубилай хааны зарилгаар босгосон байж болно. Юань улсын үед Монгол газар Бурханы шашин маш хүчтэй дэлгэрч байсныг сүүлийн жилүүдэд археологийн малталтаар илэрсэн эд өлгийн зүйлээс шууд харж болно [20, 21]. Ямар учир, юуны тулд хоёр том элсэн говийн дундах улаан уулнаа (Алашан гэх буюу ала нь улаан, шан нь уул гэсэн утгатай) увьдаст 108 суваргыг зарлигаар босгосон байж болох вэ? Цорын ганц хариу бол Юань улсын хаад Чингис хааны дурсгалд зориулж **108 суваргын тахилын онгон** босгосон байж таарна. 108 суварга босгосон газарт Чингис хаан тэнгэрт хальсан болов уу гэсэн таамгийг би дэвшүүлж байна. Энэ таамгыг батлахын тулд Монгол

Хятад улсын засгийн газар хамтран ажиллаж, хамтын экспедиц гарган археологийн малталт болон түүхийн нарийвчилсан судалгааг Нинся мужийн 108 суварганд явуулах хэрэгтэй байна.

4. Хавсралт

Ц.Батбаяр.Чингис хаан Тангудыг дайлсан аян дайны мөрөөр. Эрдэм шинжилгээний өгүүлэл. Чингис хаан ба Бурханы шашин. Гандантэгчэнлин хийдийн дэргэдэх Өндөр Гэгээн Занабазарын нэрэмжит Шашины Их Сургууль, Улаанбаатар, 2006

Монголын Нууц Товчоо. Редактор Ш.Гаадамба, Улсын хэвлэлийн газар, Улаанбаатар, 1990

Лувсандамбажалцан, Алтан товч, Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо, Хөх хот, 1998

Ah Xiang. Western Xia Dynasty

Ч. Далай. Их монгол улс, Монгол улсын шинжлэх ухааны Академийн Түүхийн хүрээлэн, Улаанбаатар, 2006

Рашид-ад-Дин, Судрын чуулган, 1-р боть

О.Шагдар. Монголчуудын аян дайн, цэргийн урлагийн түүх (XIII зуун), 1-р боть.

Алтан товч, Цоож, Дулаан. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, Хөххот, 1984.

Монголын Нууц Товчоо. Д.Цэрэнсодном, сонгомол эх, Улаанбаатар, 2006

Notes on the old Mongolian Capital of Shangtu. By S.W.Bushell, B.Sc., M.D., Physician to H.B.M. Legation, Peking. June 22, 1874, The Journal of the Royal Asiatic Society of Great Britain and Ireland. Volume the Seventh, London, 1875

Чойж. Монголын Бурханы шашины түүх, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1998.

Г.Пүрэвбат. Их Монголын суварга: онол хийгээд бүтээх ёс, Монголын Бурханы шашины урлахуй ухааны дээд сургууль, Сөүл хот, 2005

Ишбалжирийн Бурханы шашины түүх, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, Хөххот, 1993.

Fodor's Exploring China, travel guide, 2007

DK Eyewitness Travel Guides: China, 2005

Алтан Эрх, Нан Тан зохиож Цоож тулган найруулав, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1999

Алтан хүрдийн мянган хэгээдэс, Дарма гүүш, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2000

Ж.Ганболд, Т.Мөнхцэцэг, Д.Наран, А.Пунцаг. Монголын Юань улс, Монгол улсын шинжлэх ухааны Академийн Түүхийн хүрээлэн, Улаанбаатар, 2006

Л. Цэрэнчунт. Монголын эзэнт улсын нийслэл Хар Хором хот буюу одоогийн Хархорин сумын нэрийн түүхийг мөшгөхүй. Блүүмингтон хот, Индианагийн их сургууль, 2006 оны 8-р сарын 15 (www.dayarmongol.com)

Д.Наваан. Алт эрдэнэсийн дурсгал. Улаанбаатар. 2004

Tombs of Chingisids Are Still Being Found..., An interview with Dorjpagma Navaan. Interviewed by Shirchin Baatar, translated by Myagmar Saruul-Erdene. The Silkroad, Volume 4, Number1, Summer 2006, pages 55-60.

Зургийн тайлбар

Зураг 1. Нинся мужийн байршлыг харуулсан бүдүүвч зураг

Зураг 2. Microsoft MapPoint-аас авсан Нинся мужийн тодорхой зураг


Зураг 3. 108 суваргын байршлыг харуулсан зураг

Зураг 4. Хувилай хааны байгуулсан Бээжингийн цагаан суварга

Зураг 5. Нинся мужийн Жиакоу толгодын 108 суварга

Зураг 6. Гол суварганы бүтэн байдал

Зураг 7. Суваргын хооронд хүн явж гороо мөргөл хийх зай



Зураг 1




Зураг 2



Зураг 3




Зураг 4



Зураг 5



Зураг 6



Зураг 7